

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2010 он)

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201003/01. ИНЕГ-т. /Safety recommendation 201003/01. МСАА/. Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл олгох тухай иргэний нисэхийн дүрэм 61, Хүнд онгоцны агаарын тээврийн үйл ажиллагааны тухай иргэний нисэхийн дүрэм 121, Бага оврын онгоцны агаарын тээврийн үйл ажиллагааны тухай иргэний нисэхийн дүрэм 135-ын шаардлагуудыг дэлгэрэнгүй болгож дутуу заалтуудыг гүйцээх, тодорхой болгох, алдаатай үг хэллэг найрууллагыг засаж боловсронгуй болгох.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201003/02. ИНЕГ-т. /Safety recommendation 201003/02. МСАА/. Хувийн болон коммерийн нисгэгчийн газрын сургалтын цагийн доод хязгаарлалтыг тогтоож, нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл олгох шалгалтын хөтөлбөрийг нисгэгч бэлтгэх сургалтын хөтөлбөртэй уялдуулан мэдлэг, чадварыг бүрэн илэрхийлж чадахаар болгох

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201003/03. ИНЕГ-т, МИАТ ХК-д. /Safety recommendation 201003/03. МСАА, MIAT Mongolian Airlines/. Агаарын тээврийн МИАТ компанийн нисгэгч бэлтгэх болон үйлдвэрлэлийн дадлагын сургалтуудын хөтөлбөр, багш нисгэгчдийн мэдлэг, ур чадварыг шалгаж баталгаажуулах арга хэмжээ авах

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201003/04. ИНЕГ-т. /Safety recommendation 201003/04. МСАА/. Агаарын тээвэрлэгч болон Иргэний нисэхийн ерөнхий газраас гаргасан нислэгийн аюулгүй ажиллагаатай холбогдсон аливаа заавар, журам, тушаал, шийдвэрүүд нь Иргэний нисэхийн дүрмийн шаардлагуудыг зөрчихгүй, дагаж мөрдөж байх

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201003/05. ИНЕГ-т. /Safety recommendation 201003/05. МСАА/. Эрүүл мэндийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, иргэний нисэхийн итгэмжлэгдсэн эмч нарыг шилж сонгох түүнд олгох урамшуулал, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, мэргэжлийн үнэмлэх, эрүүл мэндийн гэрчилгээний уялдаа холбоог хатуу тогтоож өгөх

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201003/06. ИНЕГ-т, МИАТ ХК-д. /Safety recommendation 201003/06. МСАА, MIAT Mongolian Airlines /. Иргэний нисэхийн салбарт цалингийн харьцаа алдагдсан, төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагууд цалингийн хэт хөөрөгдөлт үүсгэсэн нь хяналт зохицуулалтын албанд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах боловсон хүчнийг шилж сонгох боломжийг хаагдуулж байгааг бодлогын түвшинд асуудлыг тавьж шийдвэрлүүлэх

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201003/07. ИНЕГ-т. /Safety recommendation 201003/07. МСАА/. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын байгууллагыг аж ахуйн үйл ажиллагаанаас ангид байх зарчмыг бүрдүүлэх, гэхдээ улс төрийн нөлөөллөөс түүний удирдлага, зохион байгуулалтыг хамгаалах, мэргэжлийн ажилчдын ур чадвар, хүсэл сонирхлыг хадгалах, цалин урамшууллын тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээг бодлогын түвшинд тавьж шийдвэрлүүлэх

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201003/08. ИНЕГ-г. /Safety recommendation 201003/08. МСАА/. Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга дүрмийн шаардлагаас чөлөөлөх эрх зүйн үндэслэл. Тавигдах шаардлагыг тодорхой болгох, дүрмийн шаардлагаас буруу чөлөөлсөн. Үүний улмаас аюулгүй ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлсөн нь тогтоогдвол хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201011/09. ИНЕГ-т, НЦУТ-д. /Safety recommendation 201011/09. МСАА, /. Нислэгийн цаг уурын төв нь Монгол улсын нисэх буудлуудын газар зүйн байрлалын онцлог, хөөрөх буух зурвасны чиглэл, тэдгээрт нислэг үйлдэх нөхцөл, шаардлагад нийцсэн, цаг хугацааны өөрчлөлтүүдийн болон дутуу өгөгдсөн нэмэлт мэдээллүүдийг бүрэн агуулсан цаг агаарын мэдээгээр хангах.

Нислэгийн цаг уурын төв нь цаг агаарын мэдээгээ дүгнэх үйл ажиллагааны стандартыг салхины чиглэлийн хувьд +, - 10 хэм, хүчний хувьд +, - 1м/сек байхаар нарийвчлан тогтоох.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201011/10. ИНЕГ-н НХУТ-д. /Safety recommendation 201011/10. МСАА/. а) Нислэгийн хөдөлгөөний удирдлагын талаар гарч байгаа доорхи зөрчлүүдийг таслан зогсоох . Үүнд:

- Нислэгийн төлөвлөгөөнд тусгагдаагүй нислэг хийхийг нислэгийн удирдагч өөрийн үзэмжээр зөвшөөрөх
- Нисэх багт арын салхины хүч, чиглэлийн хэмжээг бодит байдлаас өөрөөр мэдээлэх
- Нисэх багт өгсөн мэдээллээ бичиг баримт /стрип/ дээр өөрөөр тэмдэглэх
- Нисэх багийн буруу ойлгосон мэдээлэлийг цаг тухайд нь залруулахгүй байх /нисэх баг буруу ойлгосон даралт шилжүүлэх мэдээллийг 8 минутын дараа залруулсан байна/
- Буултын үед “зөвшөөрнө, чөлөөтэй” гэх мэт олон янзын ярианы термин хэрэглэх
- Нисэх баг нислэгийн удирдагчид хоорондоо радио-холбоогоор нислэгт холбогдолгүй үг яриа ярих.

б) Нислэгийн радио-холбооны ярианы загварчилсан хэллэгийн стандартыг, олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэдэг утга агууллагад нийцүүлэн Олон улсын стандарт, баримт бичиг 4444–ийн дагуу тогтоож баталгаажуулан мөрдөх.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201011/11. ИНЕГ-г. /Safety recommendation 201011/11. МСАА/. Нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд гарч байгаа доорхи зөрчлүүдийг таслан зогсоох. Үүнд:

- Нисэх баг ИНД-91-ийн шаардлагын дагуу бэлтгэл аэродром сонгохгүй байх
- Дүрэм журамд заасны дагуу бэлтгэлээр сонгосон аэродромд нисч хүрэх хүрэлцэх хэмжээний түлшгүй байх.
- Орон нутгийн нислэг үйлдэж буй Агаарын тээврийн компануудын нислэгийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө /Operational Flight Plan/-нд сонгож авсан бэлтгэл нисэх буудлууд түүнд хүрэх түлшний тооцоо, буцах цэгийг тооцоо хийхгүй байх
- Орон нутгийн нислэгт “нисэх замын цаг агаарын урьдчилсан мэдээ”-г авалгүй нисэх.

- Очих болон бэлтгэл нисэх буудлын цаг агаарын урьдчилсан мэдээ /TAF/, бодит мэдээ /METAR/ аваагүй байх, хугацаа дууссан мэдээ ашиглах, хүлээж авсан цаг агаарын мэдээнүүддээ дүн шинжилгээ хийхгүй байх.

- Орон нутгийн нислэгт үндсэн болон бэлтгэл нисэх буудлын хөөрөлт, буултын зөвшөөрөгдсөн нөхцлийг Монгол улсын Нислэгийн мэдээлэлийн эмхэтгэлд заасны дагуу хэрэгжүүлэхгүй байх.

- Нисэх баг, нислэгийн удирдагчаас радио-холбоогоор өгсөн мэдээллийг үндэслэлгүйгээр үгүйсгэсэн зүй бус үйлдэл гаргах

- Нисэх баг нислэгийн удирдагчид хоорондоо радио-холбоогоор нислэгт холбогдолгүй үг яриа ярих,

- Нислэгийн ашиглалтын зааварт заасан хязгаарлалтыг зөрчих.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201011/12. ИНЕГ-г. /Safety recommendation 201011/12. МСАА/. Нислэгийн мэдээллийн эмхтгэл /НМЭ/-ийн санд оруулсан мэдээллүүдийг дахин хянах, шинээр болон нэмж оруулах мэдээлэл нь баталгаажсан, үнэн зөв, хууль эрх зүйн актын хүрээнд ашиглаж болох хэмжээний баримт бичиг байх арга хэмжээ авч хэрэгжүүлэх

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201011/13. ИНЕГ-г. /Safety recommendation 201011/13. МСАА/. Олон улсын иргэний нисэхийн байгууллагууд практик үйл ажиллагаандаа өргөнөөр хэрэглэж буй, зөрчил дутагдлын талаархи мэдээлэлийг ил тод чөлөөтэй болгох тогтолцоог бүх шатанд бүрдүүлэх, үүнтэй уялдуусан дотоод хяналтын системийн үйл ажиллагааг дээшлүүлэх, байгууллага эрсдлийн удирдлагын системийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.